

САНГИЙН САЙД, ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2017 оны 01 сарын 30 өдөр

Дугаар 34/19

Улаанбаатар хот

Тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн талаар авах
зарим арга хэмжээний тухай

“Монгол Улсын Засгийн газрын тухай” хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь, “Автотээврийн тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.11, 6.1.12 дахь, “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай” хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх, “Гаалийн тухай” хуулийн 272¹ дугаар зүйлийн 272¹ 1, “Хилийн боомтын тухай” хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын нутаг дэвсгэрт ашиглагдаж байгаа автотээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэлийг 2017-2018 онд зохион байгуулсугай.

2. Тээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэлийн үйл ажиллагааг зохион байгуулах, мэргэжлийн удирдамжаар хангах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралтаар, шинэчилсэн бүртгэлийг зохион байгуулах ажлын удирдамжийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Тээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэлийн үйл ажиллагааг иргэдэд хүндрэл, чирэгдэл учруулахгүй шуурхай зохион байгуулахыг Татварын ерөнхий газар /Л.Зориг/, Гаалийн ерөнхий газар /Б.Асралт/, “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ /П.Дэлгэрнаран/, өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн яамны Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /С.Батболд/-т тус тус даалгасугай.

4. Ажлын хэсгийн тайлан, үр дүнг 2018 оны 02 дугаар сарын 01-ний дотор танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч, Зам, тээврийн хөгжлийн дэд сайд /Б.Цогтгэрэл/-д үүрэг болгосугай.



Б.ЧОЙЖИЛСҮРЭН



Д.ГАНБАТ

Сангийн сайд, Зам, тээврийн хөгжлийн сайдын
2017 оны 01 дугаар сарын 30 ны өдрийн 34/19
дугаар хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралт

Тээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэлийн үйл ажиллагааг
зохион байгуулах, мэргэжлийн удирдамжаар хангах үүрэг бүхий
ажлын хэсгийн бүрэлдэхүүн

УХА0382
5919487
116126781

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Цогтгэрэл

Зам, тээврийн хөгжлийн дэд сайд

Нарийн бичгийн дарга:

П.Мөнхбат

Зам, тээврийн хөгжлийн яамны Автотээврийн
бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын
Техникийн хяналт, тээврийн хэрэгслийн
бүртгэл хариуцсан мэргэжилтэн

Г.Энхжин

ТЕГ-ын татварын орлогын газрын татварын улсын
байцаагч
/зөвшилцсөнөөр/

Гишүүд:

С.Батболд

Зам, тээврийн хөгжлийн яамны Автотээврийн
бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга

Ц.Нэргүйбаатар

Зам, тээврийн хөгжлийн яамны Автотээврийн
бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах
мэргэжилтэн

Э.Мөнхнасан

Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого,
төлөвлөлтийн газрын Салбарын нэгдсэн бодлого,
төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн

Э.Батсүх

Зам, тээврийн хөгжлийн яамны Автотээврийн
бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Тээврийн
ухаалаг систем, мэдээллийн сан хариуцсан
мэргэжилтэн

Б.Билгүүн

Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн захиргааны
удирдлагын газрын Хуулийн хэлтсийн мэргэжилтэн

Б.Амар

ЦЕГ-ын Мэдээллийн технологийн хэлтсийн дарга,
цагдаагийн хошууч
/зөвшилцсөнөөр/

Ч.Алтантуяа


ГЕГ-ын Гаалийн хяналт, шалгалтын газрын гаалийн
улсын байцаагч
/зөвшилцсөнөөр/

Г.Эрдэнэцогт

Гадаадын иргэн, харьяатын газрын Шалган
нэвтрүүлэх газрын ахлах мэргэжилтэн

- /зөвшилцсөнөөр/
- М.Баярмаа Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалт, зохицуулалтын газрын даатгалын хяналтын чиглэлээр хянан шалгагч
/зөвшилцсөнөөр/
- Б.Гүрсоронзон “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын Тээврийн хэрэгслийн бүртгэлийн хэлтсийн дарга
- М.Эрдэнэдалай “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын Техникийн хяналтын хэлтсийн дарга
- Д.Өсөхбаяр “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын Техникийн хяналт мэдээллийн хэлтсийн программ хангамжийн мэргэжилтэн
- Д.Дашдорж Замын цагдаагийн албаны НЗХХГ-ын дарга, цагдаагийн хурандаа
/зөвшилцсөнөөр/
- Ж.Батжаргал Монголын Даатгагчдын холбооны гүйцэтгэх захирал
/зөвшилцсөнөөр/

---o0o---



Сангийн сайд, Зам, тээврийн хөгжлийн сайдын
2017 оны 01 дугаар сарын 30 ны өдрийн 34/19
дугаар хамтарсан тушаалын хоёрдугаар хавсралт

Автотээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэлийг
зохион байгуулах ажлын удирдамж

УХА0011 9131787

УХА0382
5919487
1116126781

Нэг. Зорилго:

Тээврийн хэрэгслийн бүртгэлийн тогтолцоог шинэчлэх, тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээллийн санд суурилсан хил, гааль, татвар, даатгал, засвар үйлчилгээний мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх.

Хоёр. Хугацаа:

Тээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэлийн үйл ажиллагааг 2017 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 2018 оны 02 дугаар сарын 01-ний өдөр хүртэл.

Гурав. Хэрэгжүүлэгч байгууллага:

“Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ

Хамтран хэрэгжүүлэгч байгууллагууд

- Гаалийн ерөнхий газар
- Татварын ерөнхий газар
- Гадаадын иргэн харьяатын газар
- Цагдаагийн ерөнхий газар

Дөрөв. Хэрэгжүүлэх арга хэмжээ:

4.1. Тээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэлийг техникийн хяналтын үзлэгийн үйл ажиллагаатай нэгтгэн зохион байгуулах /улсын дугаарын давхардал, тээврийн хэрэгслийн зориулалт өөрчилсөн эсэх, стандартад заагаагүй хэмжээ, өнгө, тэмдэглэгээ бүхий улсын дугаарын тэмдэг байгаа эсэхийг шалгах/;

4.2. Тээврийн хэрэгслийн бүртгэлийн болон ашиглалттай холбоотой зөрчлүүдийг арилгуулах;

4.3. Тээврийн хэрэгслийн улсын бүртгэл, татвар, даатгал, хилийн боомтоор нэвтрэх тээврийн хэрэгслийн бүртгэл зэрэгт шаардлагатай эрх зүйн баримт бичгүүдийг шинэчлэн боловсруулах;

4.4. Тээврийн хэрэгслийн бүртгэлийн дугаарын тэмдгийг тээврийн хэрэгсэлд байрлуулан лацдах;

4.5. Монгол Улсад үйлдвэрлэж, угсарч байгаа тээврийн хэрэгслийг улсын бүртгэлд бүртгэх зохицуулалтыг бүрдүүлэх;

4.6. Тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээллийн санд суурилан татвар, даатгал, гааль, хилийн нэвтрэлтийн мэдээллийн сангууд харилцан мэдээлэл солилцох зохицуулалтыг бүрдүүлэх;

4.7. Бүртгэлийн ажлыг зохион байгуулахдаа бусад холбогдох байгууллагатай хамтран ажиллах;

4.8. Сүүлийн 4-5 жилийн хугацаанд техникийн хяналтын үзлэгт хамрагдаагүй, шилжилт хөдөлгөөн хийгдээгүй, татвар төлөөгүй Монгол Улсын хилээр гараад орж ирээгүй олон жил болж байгаа тээврийн хэрэгслийн судалгааг гарган бүртгэлийн сангаас хасах;

4.9. Тээврийн хэрэгслийн бүртгэлийн нэгдсэн санг “Үндэсний дата төв” УТҮГ-т байршуулах, харилцан мэдээлэл солилцох талаар гэрээ байгуулах;

4.10. Тусгай дуут, гэрлэн дохио хэрэглэж буй тээврийн хэрэгслийг мэдээллийн нэгдсэн санд бүртгэлжүүлэх;

4.11. Монгол Улсад түр хугацаагаар бүртгэлээр оруулж ирээд гараагүй байгаа гадаад улсад бүртгэлтэй тээврийн хэрэгслийг албадан гаргах, зохих журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлэх;

4.12. Монгол Улсын хилээр тээврийн хэрэгслийг импортоор байнга оруулж ирж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд тээврийн хэрэгслийн бүртгэлийн үйл ажиллагааны талаар сургалт зохион байгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх;

4.13. Тээврийн хэрэгслийн гэрчилгээний техникийн тодорхойлолт заасан мэдээллийг Венийн конвенцод заасны дагуу бичиж, бүртгэл хөтлөх;

4.14. Тээврийн хэрэгслийн жингийн мэдээллийг нэг хэмжигдэхүүнээр бүртгэх /тонноор/;

4.15. Тээврийн хэрэгслийн бүртгэлийн сангаас хасах тээврийн хэрэгсэлд бүрдүүлэх материал болон үйл ажиллагааг иргэдэд чирэгдэл багатай хөнгөн шуурхай зохион байгуулах талаар арга зүйн зөвлөмж боловсруулах;

4.16. Тээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэлийн үйл ажиллагааг зохион байгуулахтай холбогдсон сургалт зохион байгуулах;

4.17. Тээврийн хэрэгслийн татвар, даатгал, хяналт, бүртгэл, нотариатын нэг цонхны үйлчилгээг бий болгох;

4.18. Тээврийн хэрэгслүүдэд NID /National ID/ олгох, бүртгэлжүүлэх, бусад системд хэрхэн ашиглах нөхцөлийг бүрдүүлэх;

4.19. Тээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэлийн үйл ажиллагааг зохион байгуулах талаар иргэдэд мэдээллэх, иргэд болон ААНБ бүртгэлтэй байгаа тээврийн хэрэгслээ www.transdep.mn сайтаар шалгах боломжийг бүрдүүлэх зэрэг болно.

---oOo---

